

**Аудиторын дүгнэлт**

Бид "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК (цаашид "Компани" гэх)—ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

## НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Баталсан

**Э. Булган**  
Партнер



Монгол Улс, Улаанбаатар хот  
2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

---

Нексия Глобал Монголиа Аудит ХХК  
Нексия Интернэйшнл-ийн албан ёсны гишүүн  
Веб: [www.nexia.com](http://www.nexia.com)

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
ТУСДАА САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянаан төгрөгөөр	Тод	2025-12-31	2024-12-31
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	7	258,068	260,295
Биет бус хөрөнгө	8	6,476,409	500,764
Ашиглах эрхтэй хөрөнгө	9	838,212	4,161,784
Урт хугацаат хөрөнгө оруулалт	10	49,169,436	51,612,805
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-	576
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>56,742,125</b>	<b>56,536,224</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11	7,581	5,202
Дансны болон бусад авлага	12	61,025,046	51,981,471
Бараа материал	13	85,467	111,794
Урьдчилж төлсөн тооцоо	14	1,523,245	1,867,500
Бусад санхүүгийн хөрөнгө	15	277,424	248,724
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		-	4,095,647
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>62,918,763</b>	<b>58,310,338</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>119,660,888</b>	<b>114,846,562</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өр төлбөр	16	39,334,019	32,120,066
Богино хугацаат зээл	17	6,024,244	5,866,254
Урьдчилж олсон орлого	18	7,396,988	7,525,707
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	19	3,520,000	370,000
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	9	392,493	1,319,671
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>		<b>56,667,744</b>	<b>47,201,698</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	17	9,611,853	8,852,663
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	9	437,134	2,963,093
Хойшлогдсон татварын өр төлбөр	20	367,955	1,207,756
Бусад нөөц өр төлбөр	21	1,057,971	-
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>		<b>11,474,913</b>	<b>13,023,512</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>68,142,657</b>	<b>60,225,210</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	22		
Хувийн өмч	22.1	28,614,263	28,614,263
Нэмж төлөгдсөн капитал	22.1	492,181	2,927,696
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.2	3,789,108	1,803,519
Эздийн өмчийн бусад хэсэг	22.2	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	22.3	18,608,881	21,262,075
<b>Нийт эздийн өмч</b>		<b>51,518,232</b>	<b>54,621,352</b>
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>		<b>119,660,888</b>	<b>114,846,562</b>

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025	2024
Менежментийн үйлчилгээний орлого	23	3,596,651	3,513,280
Ногдол ашгийн орлого	24	8,071	871,915
Хөрөнгө оруулалтын борлуулалтаас үүссэн олз		311,862	5,590,160
<b>Нийт орлого</b>		<b>3,916,584</b>	<b>9,975,355</b>
Борлуулалт, маркетингийн зардал	25	(128,154)	(685,751)
Ерөнхий ба удирдлагын зардал	26	(5,204,979)	(5,517,215)
Бусад зардал	27	(158,908)	(351,230)
<b>Үйл ажиллагааны ашиг/алдагдал</b>		<b>(1,575,457)</b>	<b>3,421,159</b>
Санхүүгийн зардал	28	(3,495,974)	(3,105,296)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	29	(406,557)	(67,135)
Виртуал хөрөнгийн үнэлгээнээс үүссэн олз (гарз)	30	6,306,780	(412,132)
Бусад олз (гарз)	31	145,502	
<b>Татвар төлөхийн өмнөх алдагдал (ашиг)</b>		<b>974,294</b>	<b>(163,404)</b>
Орлогын татварын зардал (нөхөлт)	32	21,540	255,926
<b>Тайлант үеийн цэвэр алдагдал (ашиг)</b>		<b>995,834</b>	<b>92,522</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Виртуал хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт		1,985,588	(29,819,473)
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын дүн</b>		<b>2,981,422</b>	<b>(29,726,951)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		<b>0.10</b>	<b>(1.04)</b>

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж телегдсэн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>2,927,696</b>	<b>28,362,014</b>	<b>13,799</b>	<b>24,344,457</b>	<b>84,262,229</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	-	-	-	-	86,074	86,074
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>2,927,696</b>	<b>28,362,014</b>	<b>13,799</b>	<b>24,430,531</b>	<b>84,348,303</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	92,522	92,522
Хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт	-	-	(29,819,473)	-	-	(29,819,473)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	3,260,978	-	(3,260,978)	-
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>2,927,696</b>	<b>1,803,519</b>	<b>13,799</b>	<b>21,262,075</b>	<b>54,621,352</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	-	-	-	-	25,512	25,512
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>2,927,696</b>	<b>1,803,519</b>	<b>13,799</b>	<b>21,287,587</b>	<b>54,646,864</b>
Тайлант жилийн ашиг	-	(2,435,515)	-	-	995,834	(1,439,681)
Хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт	-	-	2,735,714	-	-	2,735,714
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(750,125)	-	(3,674,540)	(4,424,665)
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>492,181</b>	<b>3,789,108</b>	<b>13,799</b>	<b>18,608,881</b>	<b>51,518,232</b>

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025	2024
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>3,380,343</b>	<b>2,344,641</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,380,343	2,344,961
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-	75
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-	605
<b>Мөнгө зарлагын дүн</b>		<b>8,976,165</b>	<b>7,034,217</b>
Ажиллагчдад төлсөн		773,095	1,309,585
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		225,000	294,556
Бараа материал худалдан авахад төлсөн		78,924	-
Ашиглалтын зардалд төлсөн		145,021	39,649
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		60,651	96,069
Хүүний төлбөрт төлсөн		3,674,288	1,070,007
Татварын байгууллагад төлсөн		780,223	100,604
Даатгалын төлбөрт төлсөн		16,724	16,554
Бусад мөнгөн зарлага		3,222,239	4,377,191
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг/(алдагдал)</b>		<b>(5,595,822)</b>	<b>(4,689,574)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>18,537,247</b>	<b>39,672,400</b>
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		522,959	56,337
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		17,406,041	39,557,503
Хүлээн авсан хүүгийн орлого		600,176	6,772
Хүлээн авсан ногдол ашиг		8,071	51,788
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>12,218,433</b>	<b>40,352,900</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		271,000	42,541
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		11,947,433	18,389,702
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-	21,920,657
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>6,318,814</b>	<b>(680,500)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>5,147,948</b>	<b>14,648,028</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		5,147,948	14,648,028
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>5,868,560</b>	<b>9,601,554</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		5,868,560	9,601,554
Төлсөн ногдол ашиг		-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(720,612)</b>	<b>5,046,474</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)</b>		<b>2,380</b>	<b>(323,600)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний Үлдэгдэл</b>		<b>5,202</b>	<b>328,802</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>7,581</b>	<b>5,202</b>